

## **SUMMARY OF NEWS PAPER COVERAGE ON THE “OPENING OF FESTIVAL OF INDIA IN MONGOLIA: 2015-2016”**

The following four Mongolian Daily Newspapers published materials on occasion of the opening of “Festival of India in Mongolia: 2015-2016”

No	Title of the Dailies	Date of Publication	Author and Title of the Publications
1.	Zuunii Medee Daily Newspaper	9 <sup>th</sup> November, 2015	By S. Uyanga. “Relations of Intellectual Neighbors were expressed with percussion instruments and historical photos”
2.	Mongoliin Medee Daily	9 <sup>th</sup> November, 2015	By B. Davaa. “Intellectual Neighbors had culture “breaths” for one day”
3.	Ardchilal Daily	9 <sup>th</sup> November, 2015	By E. Gantsetseg. “Mongolia India Relations with 60-Years of History”
4.	Undesnii Shuudan	10 <sup>th</sup> November, 2015	By B. Tuya. “Mongolia-India has 2000 years of historic relations”

### **BRIEF SUMMARY OF THE PUBLICATIONS:**

The Opening of India’s Cultural Days entitled as “Festival of India in Mongolia: 2015-2016” has successfully opened its activities on last Saturday at Capital City’s Central Culture Palace. The opening of Indian Festival occasioned on the 60<sup>th</sup> Anniversary of diplomatic relations between Mongolia and India. Visitors watched with great interest photos which were displayed in the halls of Central Culture palace: photos of historic visits of leaders of our two countries and of the other significant events of relations and cooperation between our two friendly nations.

Mr. Somnath Ghosh, Ambassador of India to Mongolia, Hon’ble MP Mr. D. Demberel, Head of Mongolia India Parliamentary Group of the State Ikh Hural (Parliament) of Mongolia, and Hon’ble MP Yo. Otgonbayar, heads of foreign diplomatic missions, monks representing largest Buddhist temples of Mongolia, students and representatives of Mongolia society took part in the opening ceremony of “Festival of India in Mongolia: 2015-2016.”

Ambassador Somnath Ghosh addressing the opening this event emphasized that India was the first country outside of so-called “left-bloc” to establish diplomatic relation with Mongolia. MP D. Demberel emphasized that Mongolia and India have the deep-rooted cultural and religious ties since the ancient times.

Drums of India attracted the significant interest from Mongolian audience. Ambassador Somnath Ghosh explained that these drums have arrived from different corners of India, despite of it, players created a single ensemble of percussion instrument to play at the stage of Mongolia expressing the uniqueness and unity of Indian nation and its culture.

The opening of the festival was over with the taste of Indian food and tea expressing the hospitality and friendship of Indian people for people of Mongolia. As a whole, the event was the great success of Indian cultural activities that would continue over a period of few months in 2015 and 2016.

P. G. Dzinti Medee 9th Nov 2015  
**Өдрийн сурвалжлага**

## Оюун санааны хөршүүдийн харилцааг цохивор хөгжим, түүхэн зургаар илэрхийллээ



БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Сомнат Гхош, УИХ дахь Монгол-Энэтхэгийн парламентын бүлгийн дарга Д.Дэмбэрэл нар уламжлал ёсоор нээлтийн зул асаав

### С.УЯНГА

Бүгд найрамдах Энэтхэг улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан “Монгол дахь Энэтхэг фестиваль 2015-2016” арга хэмжээ өнгөрсөн бямба гаригт амжилттай болж өндөрлөлөө. Фестивалийг зорин ирсэн зочид төлөөлөгчид Энэтхэг Монголын харилцааны талаарх түүхэн гэрэл зургийн үзэсгэлэнг шимтэн сонирхов. Тус үзэсгэлэнд хоёр улсын ерөнхийлөгч нарын айлчлал, түүхэн олдворуудаас эхлээд сонирхолтой үйл явдлуудын баримтыг дэлгэжээ.

Хүлээн зөвшөөрсөн хамгийн анхны улс бол Энэтхэг. Манай хоёр улс хэл, шашин соёлоороо эртнээс холбогдох ирсэн бөгөөд 2000 гаруй жилийн түүхэн харилцаатай гэдгийг дурдахад таатай байна. 2013 онд Энэтхэгийн Ерөнхий сайд айлчлахдаа хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүрсэн гэдгийт мэдэгдсэн. Манай хоёр улсын харилцаа олон мянган жилийн өмнө буддист лам нар олон мянган бээрийг туулж ирснээс эхэлсэн гэж үзж болох юм. 1500 гаруй жилийн өмнө Монголоос

Энэтхэгийн их сургуульд очиж суралцаж байсан түүхэн баримт бий. Төвийг нээхээр ажиллаж байна. Хоёр улсын харилцаа маш олон сэжмээр холбоотой”-г онцоллоо.

УИХ дахь Монгол-Энэтхэгийн парламентын бүлгийн дарга Д.Дэмбэрэл “Энэтхэг, Монгол Улс өнө эртний олон талын харилцаатай. Хоёр улсын харилцаа бүх төвшинд хөгжих байгаа. Тэр дундаа парламентын харилцаа тогтоосны 60 жил буюу нэгэн жарны хугацаанд хоёр улсын найрсаг харилцаа олон талаар хөгжих ирсэн” гэв.

Монгол дахь Энэтхэг фестивальд Улаанбаатарт айлчлан, тоглолт

Соёлын арга хэмжээнд БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд, эрхэмсэг ноён Сомнат Гхош, УИХ дахь Монгол- Энэтхэгийн парламентын бүлгийн дарга Д.Дэмбэрэл, УИХ-ын гишүүн Ё.Огонбаяр нараас гадна дипломатчид, сүм хийдүүдийг төлөөлөн ирсэн лам нар, Энэтхэгт суралцсан залуучууд, хүүхдүүд оролцсон юм.

Ноён Сомнат Гхош арга хэмжээг нээж уг хэлэхдээ “60 жилийн өмнө социалист гэгдэж байсан орнуудад хамаардаггүй Монгол Улсын тусгаар тогтолцогт

Энэхүү өв уламжлалыг үргэлжүүлээд шашны болон өөр төрлөөр Энэтхэгт суралцахаар очсон монголчуудын тоо 1500-д хүрчээ. Техник эдийн засгийн хүрээнд их, дээд сургуульд суралцагчдын тоо хэдэн мяняга давсан. Мөн Монгол дахь Ражив Гандийн нэрэмжит үйлдвэр урлалын политехник коллеж, Энэтхэгийн Засгийн газрын тэтгэлэгтэйгээр байгуулсан факультетуудыг 6000 гаруй оюутан төгссөн. Бид бас Монголын ШУТИС-тай хамтраад Мэдээлэл холбоо, технологийн

хийж байгаа Энэтхэг хөгжимчдийн хамлагаас бөмбөрийн тоглолт зочдын сонирхлыг татав. Тоглолтын талаар Элчин сайд эрхэмсэг ноён Сомнат Гхош хэлэхдээ “Энэтхэг улсад дэлгэрсэн бөмбөрийн хийц хэлбэр, нэр төрөл маш олон тул тэдгээрийг нэгтгэн нэгэн найрал хөгжим тоглуулна гэдэг төсөөлөхөд ч хэцүү. Гэсэн хэдий ч энэ үзүүлбэр олон зуны туршид хуримтлуулсан туршлагад үндэслээд аль болох олон төрлийн сонгодог айзам хэмнэлээр зочдын сонорыг мялаадаг. Зүйрлэвэл өнгө өнгийн цэцгэн эрхи мэт” гэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ Р.蒙古のMedee 9th Nov 2015

# “ОЮУН САНААНЫ ХӨРШ”-ийн соёлоор нэг өдөр “АМЬСГАЛАВ”

—“Энэтхэг фестиваль 2015–2016”—ын нээлтийн  
ажиллагаа боллоо—

## Б.ДАВАА

Монгол, Энэтхэг улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тохиолдуулан Энэтхэгийн Элчин сайдын яамнаас “Энэтхэг фестиваль 2015–2016”-г зохион байгуулж байна. Энэхүү фестивалийн нээлтийн үйл ажиллагаа өнгөрөгч бямба гарагт Соёлын төв өргөөний тайзнаа болж, монголчууд, Монголд ажиллаж амьдарч буй энэтхэгчүүд Энэтхэгийн соёл

урлагаар “амьсгалан” нэгэн үдшийг өнгөрүүллээ. Монгол Энэтхэгүүсийн харилцаа холбоо олон мянган жилийн өмнөх тэртээх үе рүү хөтлөх бөгөөд хоёр орны харилцааг илтгэх хамгийн эртний олдворууд Хүннү гүрний үеэс улбаатай ажээ. Нэг шашны нийтлэг үнэт зүйлийн дор нэгдсэн хоёр орны хооронд соёл боловсрол болон шинжлэх ухааны хэлхээ холбоо гүнзгийрч, үүнээс улбаалан Монгол улс Энэтхэгийг “Оюун санааны хөрш” хэмээн нэгэнтээ

тодорхойлсон байdag билээ. Тэгвэл хоёр орон албан ёсоор дипломатхарилцаатогтоосноос хойш нэгэн жарныг ардаа уджээ. Ойн хүрээнд зохиогдож буй “Энэтхэг фестиваль 2015”-2016” наадмын нээлтийн ажиллагаа Монгол улсад зохион байгууллагдах соёлын арга хэмжээнүүдийн зөвхөн эхлэл нь гэдгийг ч зохион байгуулагчдын зүгээс онцолж байсан юм.

Үргэлжлэл нь IV нүүрт

## p.4. "Mongolian Medee" — continued — МЭДЭЭЛЭЛ —

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Нээлтийн ажиллагаанд БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Сомнат Гош, УИХ-ын гишүүн, Энэтхэг, Монголын парламентын бүлгийн дарга Д.Дэмбэрэл нарын эрхэм хүндтэй төлөөлгөчдөөс гадна шашны сургуулийн лам нар, Энэтхэг улсад сурч байсан оюутан, запус, Монголд амьдарч буй энэтхэгчүүд хүрэлцэн ирсэн байлаа. Энэтхэгийн фестивалийг нээж, Элчин сайд Сомнат Гош үг хэлэв. Тэрбээр Соёлын төв оргөөний их танхимд хүрэлцэн ирсэн зочдод талархал илэрхийлэхин хамтаар “60 жилийн өмнө социалист гэгдэж байсан орнуудад хамаардаггүй хамгийн анхны Монгол Улсын тусгаар тогтолыг хүлээн зөвшөөрсөн орнуудын нэг бол Энэтхэг байлаа. Хэдийгээр 60 жилийн өмнө манай хоёр улс албан ёсоор дипломат харилцаа тогтоосон байдал ч, Энэтхэг Монголулсын харилцаат түүнээс ч илүү буюу 2000 жилийн түүхтэй гэж хэлж болно. Хэл,

хамтлаг хүрэлцэн ирж, уламжлалт хөгжмийн урлагийн дээжээс монголчуудад сонирхуулсанаас гадна монголын авьяастнууд Энэтхэгийн соёл урлагаас толилуулж, ирсэн зочдын мэлмийг баясгалаа. Зуу гаруй хэлээр ярилцдаг олон үндэстэн ястны өлгий нутаг болсон Энэтхэг оронд нутаг нутгийн онцлог, зан заншил, хэл соёлоос шалтгаалаад хүмүүний сонорыг мляаах цохивор хөгжмийн олон төрлийг нэн эртнээс хөгжүүлж иржээ. Тэмдэглэлт ёслол, баяр наадмын үеэр нийгмийн харилцааны тоолшгүй олон өнгө аасыг нутаг орон бүрт өөр өөрийн онцлог бүхий цохивор хөгжмийн зэмсэг ашиглан тухайлсан хэм хэмнэлээр дамжуулан илэрхийлдэг байна. “Энэтхэг бөмбөр” хэмээх тус хамтлаг хойд энэтхэгээс гаралтай tabla, пакаваж, Өмнөд энэтхэгээс үүсэлтэй мридангам, ченда, маддалам, эдакка, талам, зүүн энэтхэгээс эхтэй мардала, тхул, нагада, зүүн хойд энэтхэгийн пунг, тхул зэрэг бөмбөрүүдээс бүрджээ. Эдгээр зэмсгүүдийн

...Энэ үзүүлбэр “Шанкх” хэмээн дун үлээх үзүүлбэрээр эхэлсэн бөгөөд хөгжимчдийн ур чадварыг илэрхийлэх гоцлолуудаар үргэлжилж, нэгдсэн найралт айзмаар өндөрлөсөн юм. Уламжлалт хөгжмийн хамтлаг гэхээр уйтгартай гэж ойлгох нь өрөөсгөл юм билээ...

Энэтхэг хоёр улсын түүхэн харилцааг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн гарчээ. Орох хаалгаар ормогц л гэрэл зургууд хананд өлгөөстэй байх бөгөөд тэртээ 1959 оны есдүгээр сард Монгол Улсын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалын 1959 онд Бүгд Найрамдах Энэтхэг Улсад айлчилж, тухайн үеийн Ерөнхий сайд Жавахарлал Нерутай уулзалт хийж буй түүхэн гэрэл зургнаас эхлээд 2015 хүртэлх хоёр улсын харилцааны түүхэн гэрэл зургууд дэлгэгдсэн байлаа. Үүнээс гадна 1988 оны долдугаар сард Энэтхэгийн Ерөнхийлөгч Рамасвами Венкатараманы Монгол Улсад айлчлах үеэр авсан гэрэл зураг, манай улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди нарын дипломат сельфи зураг өлгөөстэй байсан нь олны сонирхлыг ихэд татаж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй болов уу. Монгол, Энэтхэг хоёр улс түүх, соёл, урлагийн ямар их хэлкэ холбоотойг харуулахыг зорьсон энэ удаагийн фото зургийн үзэсгэлэн ч олны

соёл, шашин шүтлэгээрээ эрт дээр үеэс бид холбогдож ирсэн билээ. 2015 оны тавдугаар сард Энэтхэг улсын Ерөнхий сайд Нарендра Моди Монгол Улсад айлчлахдаа хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүрсэн гэж мэдэгдсэн. Хэдэн зуун жилийн өмнө Энэтхэгийн буддист лам олон мянган бээрийг туулан Монголд ирсэнээр манай хоёр улсын харилцааны шав тавигдсан түүхтэй. 1500 жилийн өмнө Монголоос Наландагийн их сургуульдочижсуралцажбайсан гэсэн баримт гарч ирснийг энд дуулгахад таатай байна. Тэрхүү уламжлалыг үргэлжлүүлээд шашны сургуульд суралцахаар очсон Монгол лам нарын тоо эдүгээ 1500-д хүрчээ. Шашинаас гадна Энэтхэгийн техник эдийн засгийн хамтын ажиллагааны тэтгэлгийн хүрээнд 1500 гаруй оюутан богино хугацааны сургалтад хамрагдсан байна. Мөн их дээд сургууль төгссөн оюутнуудын тоо ч их байгаа. Оюутнуудыг Энэтхэг руу илгээхээс гадна Монголд байгаа Ражив Гандийн нэрэмжит үйлдвэр урлалын политехникийн коллежийн сургуульд Энэтхэгийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон палуктетийг өнгөрсөн хугацаанд 6000 гаруй оюутан суралцаж төгссөн гэдгийг дуулгахад таатай байна. Үүнээс гадна ШПУГИС-тай хамтарч Мэдээлэл холбоо технологийн болон аутсорсингийн төвийг нээхээр ажиллаж байна” хэмээн тэмдэглэсэн юм. Мөн УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэлийг тайзнаа урьж, Энэтхэг уламжлалын дагуу нээлтийн зулыг асааснаар фестивалийн нээлтийн арга хэмжээ албан ёсоор эхэллээ.

### Уйдах хором үгүй “Энэтхэг бөмбөр”-ын тоглолт

Энэтхэг фестивалийн нээлтэд Энэтхэгийн уламжлалт хөгжмийн “Энэтхэг бөмбөр”

айзам, хэм хэмнэл нь хоронодоо ялгаатай бөгөөд зүйрлэвэл өнгө өнгийн цэцгийг хэлсэн эрхи мэт төрөл бурийн хэм хэмнэл, илэрхийллийг агуулдаг байна. Харин тэдгээрийг нэгтгэн нэгэн найрал хөгжим тоглуулна гэдэг үнэхээр төсөөлөхд ч бэрх зорилт аж. Гэсэн хэдий ч олон зууны туршид хуримтуулж ирсэн туршилага дээрээ үндэслэн аль болох олон төрлийн сонгодог айзам хэмнэлээр үзэгчдийн сонорыг мэлаасан юм. Өөр өөр хэллээр ярилцдаг, өөр өөр мужуудаас цугласан “Энэтхэг бөмбөр” хамтлагийн 13 гишүүн гагцхүү бөмбөрийн цохилтоороо нэгдэж, сэтгэлд хоногшим гайхам үзүүлбэрийг сонирхуулж, зарим үзэгчдийг суудлаасаа өндөлзтэл, харин заримынх нь сэтгэлийг баясгаж, сонорыг нь мэлаасан гайхамшигт үзүүлбэрийг сонирхуулж байлаа. Энэ үзүүлбэр “Шанкх” хэмээн дун үлээх үзүүлбэрээр эхэлсэн бөгөөд хөгжимчдийн ур чадварыг илэрхийлэх гоцполуудаар үргэлжилж, нэгдсэн найралт айзмаар өндөрлөсөн юм. Уламжлалт хөгжмийн хамтлаг гэхээр уйтгартай гэж ойлгох нь өрөөсгөл юм билээ. Энэтхэгийн өнцөг булан бүрээс ирсэн гайхам авьяаслаг запуусын гар өвөрмөц хэлбэр дурс бүхий бөмбөр дээр бужиглэх мэт хурдан шаламгай хөдлөх агаад цохилт бүрт гайхамшигт аяз эгшиглэж, ойролцоогоор 30 гаруй минут үргэлжилсэн хэдий ч тэнд хурэлцэн ирсэн үзэгчдэд уйдах хором өгөөгүй юм. Тогтолт монгол авьяастнуудын дэлхий дахинаа дэлгэрсэн Болливудын киноны бүжгийн үзүүлбэр, Иогийн дасгалаар үргэлжилж байлаа. НҮБ-аас Иогийн ач холбогдлын хүлээн зөвшөөрч, жил бурийн зургадугаар сарын 21-ийг олон

улсын иогийн өдөр болгосон байдаг. Үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэгээс үл хамааран дэлхийн 193 орны сая сая хүмүүсийн хамтаар Монгол Улс 2015 оны зургадугаар сарын 21-ний өдрийг хамтран тэмдэглэсэн бөгөөд зөвхөн Чингисийн талбайд гэхэд 1000 гаруй хүн цугласан билээ.

### Энэтхэг үндэсний хоол хийгээд гэрэл зургийн үзэсгэлэн

Соёлын төв өргөөний үүдэн хэсгийн танхимд Монгол



талаархлыг хүлээж байв. Өнөөртний харилцаатай “Оюун санааны хөрш” улсын амттай хоол ч энэ үдэш хүрэлцэн ирсэн эрхмүүдийн таашаалд нийцэж байлаа. “Намсти” гэх Энэтхэг ресторони тогооч нар монголоор орчуулж хэлбэл, төмстэй хуушуур болон Жалеби гэх амттангаар ирсэн зочдыг дайлж байсан юм. Мөн Энэтхэг сүүтэй цай хийгээд кофе зоогийн ширээнд өрөөстэй байлаа. Намсти рестораны ахлах тогооч Кумарын хэлж буйгаар Энэтхэг фестивалийн нээлт болж буй тул махгүй хоолоор үзэгчдийг дайлжээ. Цаг агаарын онцлог, шашин шүтлэгээс шалтгаалан Энэтхэг ард түмний 60 гаруй хувь нь цагаан хоолтон байдал аж. Энэтхэг үндэсний урлаг, хоолыг анх удаагаа сонирхож ирсэн хүмүүс ч “Бөмбөрийн үзүүлбэр гайхалтай байлаа. Харин цай нь их чихртэй байдал юм байна. Хоол нь ч гэсэн амттай сайхан байлаа” гэсэн сайшалын үгийг биднээр дамжуулан. Энэтхэгийн элчин сайдын яаманд дайж байсныг энэ дашрамд дамжуулья. Ингээд хүрэлцэн ирсэн зарим зочдын сэтгэгдлийг сонссоноо хүргэж байна.

5)

## МОНГОЛЫН МЭДЭЭ

# АНЫ ХӨРШ"-ИЙН ЁЛООР НЭГ ӨДӨР “АМЬСГАЛАВ”

—“Энэтхэг фестиваль 2015–2016”—ын  
нээлтийн ажиллагаа боллоо—

Д.Баатар: Хоол ч амттай, урлагийн  
үзүүлбэрүүд нь ч сонирхолтой сайхан арга  
хэмжээ боллоо



—Энэтхэг фестивалийн  
нээлтийн арга хэмжээнд  
оролцсондоо сэтгэл үнэхээр  
өндөр байна. Энэтхэг явж  
байгаагүй. Гэхдээ Монгол  
Энэтхэг улсын харилцаа 2000  
жилийн түүхтэй гэж ярьж  
байна. Хүү, охин хоёр маань  
Энэтхэгт сургууль төгссөн.  
Холбоо мэдээллийн чиглэлээр

магистрийн зэрэг хамгаалж байсан юм. Мэдээлэл  
технологийн салбартаа Энэтхэг улс дэлхийд тэргүүлдэг.  
Тэр ч утгаараа хүүхдүүдээ энэ улсад суралцуулсан юм.  
Монгол дахь Энэтхэгийн Элчин сайдын яам ч маш  
том дэмжлэг үзүүлсэнд баяртай байгаа. Хоол ч амттай,  
урлагийн үзүүлбэрүүд ч сонирхолтой сайхан арга хэмжээ  
боллоо гэж дүгнэж байна.

Б.Эрдэнэтуяа: Энэтхэгийн Засгийн  
газраас залуус биднийг үргэлж дэмждэгт  
баярладаг



—Монгол Энэтхэг улсын  
хооронд дипломат харилцаа  
тогоосны 60 жилийн  
ойд зориулсан Энэтхэг  
фестивалийн нээлтийн  
ёслолд оролцсондоо баяртай  
байна. Энэ удаагийн ёслол  
өргөн дэлгэр хүрээтэй  
зохиогдож байна. Миний хувьд  
Болливудын киноны дуун

дээр бүжиглэсэн. Багаасаа Энэтхэг кино үзэж өссөн учир сонирхолоороо бүжгийг нь сурсан. Энэтхэгийн соёлын төвийн харьяа Энэтхэгийн элчин сайдын яамны дэргэдэх Хинди хэлний курс байдаг. Тэнд сурч байгаад 2011-2013 онд Энэтхэг явж, Хинди хэл сурч байсан. Энэтхэгийн Засгийн газраас Монголын залуучууд, оюутнуудад хандсан дэмжлэгийг их үзүүлж байгаад баяртай байдал. Богино хугацааны болон магистр, докторантын чиглэлээр Энэтхэгийн Засгийн газрын тэтгэлэгтэйгээр олон монгол залуус маань мэргэжлээ дээшлүүлж, чанартай боловсролыг эзэмшиж байна.

## Н.Эрдэнэбилэг: Эдийн засаг, соёл урлагаар дамжуулаад хоёр орны харилцаа өндөр төвшинд хүрчээ



-Энэтхэг фестивальд анх удаагаа оролцож байна. Их агуу хөгжмийн урлагтай ард түмэн гэдгийг Монголын ард түмэнд үзүүлж байгаа нь их сайхан санагдлаа. Ер нь өнө эртнээс Энэтхэгийн ард түмэн болон Монголын ард түмний хооронд шашны болон соёлын харилцаатай байж

ирсэн. Энэтхэг Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан арга хэмжээ сайхан эхэлж байна гэж хувь хүнийхээ хувьд дутгнэж байна. Эдийн засаг, соёл урлагаар дамжуулад хоёр орны харилцаа өндөр төвшинд хүрчээ. Анх удаа Энэтхэг хоолыг энд амсч үзлээ. Энэтхэгийн үндэсний хоол их сайхан амтгай байдаг юм байна. Хоол нь сайхан учир ард түмэн нь ч гэсэн найрсаг болов уу гэх бодол төрлөө.



p. 10. № 216, Undesnii Shireen, 10th Nov 15.

**СОЁЛЫН ӨДӨР**

# МОНГОЛ-ЭНЭТХЭГ УЛС 2000 ЖИЛИЙН ТҮҮХЭН ХАРИЛЦААТАЙ


**В.ТУЯА**

Энэтхэг Улс Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан “Монгол дахь Энэтхэг фестиваль 2015-2016” арга хэмжээ боллоо. Уг соёлын арга хэмжээнд УИХ дахь Монгол Энэтхэгийн парламентын бүлгийн дарга Д.Дэмбэрэл, УИХ-ын гишүүн Е.Отгонбаир болон дипломат албаныхан, сүм хийдүүдийг төлөөлж лам нар, тус улсад суралцаж төгссөн оюутан залуус оролцсон юм. Энэ үеэр БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Сомнат Гхоштой ярилцлаа.

-Энэтхэг Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан соёлын фестиваль болж байна. Энэ арга хэмжээнд олон хүн хүрэлцэн ирсэн байна. Ийм олон зочид хүрэлцэн ирсэн нь Энэтхэг Монгол Улсын харилцаа улам өргөжиж байгаагийн илрэл юм болов уу. Та энэ тал дээр юу гэж бодож байна?

-Сайхан асуулт байна. Бид дөнгөж сая ирээд яг таны асуултын тухай ярилцаж байлаа. Соёлын төв өргөөнд багтах хэмжээний зочид ирнэ гэж тооцсон ч түүнээс олон хүн ирсэн нь сайхан сэтгэгдэл төрүүллээ. Өнгөрсөн хугацаанд Энэтхэг Монгол Улсын харилцаа ихээхэн ойртож үүнийг дагаад Энэтхэг улсад суралцагчдын тоо нэмэгдэж байгаагийн нэг илрэл болов уу. Нөгөө талаар 60 жилийн өмнө социалист гэгдэж байсан орнуудад хамаардагтүй Монгол Улсын тусгаар тогтолыг хүлээн зөвшөөрсөн хамгийн анхны улс бол Энэтхэг. Манай хоёр улс хэл, шашин соёлороо эртнээс холбогдох ирсэн бөгөөд 2000 гаруй жилийн түүхэн харилцаатай гэдгийг хэлэхэд таатай байна.

-Сүүлийн жилүүдэд манай улсаас Энэтхэг улсад суралцагчдын тоо өмнөх үеэс




нэмэгдсэн гэсэн тоо байна. Та энэ талаар тодорхой мэдээлэл огөхгүй юу?

-Энэтхэг, Монгол Улсын харилцааг түүхэн талаас нь үзвэл олон мянган жилийн өмнө буддист лам нар олон мянган бээрийг туулж ирснээс эхлсэн гэж үздэг. Өөрөөр хэлбэл, 1500 гаруй жилийн өмнө Монголоос Энэтхэгийн их сургуульд очиж суралцаж байсан түүхэн баримт бий. Энэхүү өв уламжлалыг үргэлжлүүлээд шашны болон өөр терлөөр Энэтхэгт суралцахаар очсон Монголчуудын тоо 1500-д хүрсэн байна. Сүүлийн жилүүдэд техник эдийн засгийн хүрээнд их, дээд сургуульд суралцагчдын тоо хэдэн мянга давсан. Мөн Монгол дахь Ражив Гандийн нэрэмжит үйлдвэр урлалын политехникийн коллеж, Энэтхэгийн Засгийн газрын тэтгэлэгтэйгээр байгуулсан факультетуудыг 6000 гаруй оюутан төгссөн. Мөн Монголын ШУТИС-тай хамтраад Мэдээлэл холбоо,

технологийн төвийг нээхээр ажиллаж байна гэсэн юм.

Соёлын фестивалийн үеэр УИХ-дахь Монгол-Энэтхэгийн парламентын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл, “Энэ жил Энэтхэг Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой болж байна. Өнгөрсөн хугацаанд хоёр орны парламентын харилцаа өнөөр төвшинд байсан. Би УИХ-ын даргаар ажиллаж байх хугацаанддаа Энэтхэг улсад айлчилж байв. Энэхүү айлчлал хоёр орны гадаад бодлого, хамтын ажиллагаанд чухал үүргэг гүйцэтгэсэн гэж бодлог. Мөн 2013 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Монгол Улсад айлчлах үеэрээ хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүрсэн гэдгийг мэдэгдсэн. Энэтхэг Монгол Улсын хамтын ажиллагаа өнөөдрийн төвшинд хүрэхэд хоёр талын оролцоо ихээхэн үүрэгтэй байсан юм” гэлээ.

■ ТЭМДЭГЛЭЛТ ӨДӨР D.6 №191 Ardashilal 9д N  
НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХТ МОНГОЛ  
No. 1, 2015



► Э.ГАНЦЭЦЭГ

-Монгол Улс Энэтхэг улстай, 1955 оны арванхоёрдугаар сарын 24-нд дипломат харилцаа тогтоосон. Дипломат харилцаа тогтоосон анхны социалист бус орон нь Энэтхэг улс болсон түүхтэй.

-Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Пратиба Патильын урилгаар 2009 оны есдүгээр сарын 13-16-нд Энэтхэг Улсад улс төрийн айлчлал хийв. Энэ үеэр хоёр улс уран нийлүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан төдийгүй "Иж бүрэн түншлэлийн хамтарсан тунхаглал" байгуулж, хоёр улсын харилцаа шинэ түвшинд хүрсэн.

-Энэтхэгийн Ерөнхийлөгч Пратиба Дэвисингх Патил анх удаа Монголд айлчлав.

-Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди энэ оны тавдугаар сарын 16-18-нд Монгол улсад айлчилсан билээ. Уг айлчлал нь хоёр орны харилцааг стратегийн түвшинд аваачсан томоохон хэмжээний айлчлал болсон юм.

-Хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд жилд манай улсын 30 оюутан Энэтхэг улсын Засгийн газрын тэтгэлгээр тус улсад суралцаж байна. Өдгөө манай улсын 1000 гаруй оюутан Энэтхэгт суралцаж байгаа.

-Өнгөрсөн 60 жилийн хугацаанд Монгол Энэтхэгийн хооронд 40 гаруй гэрээ, хэлэлцэр хийгдэж, хоёр орны худалдааны эргэлт 2008 онд 20 сая ам.доллар байсан бол 2011 онд 46 сая болж өсчээ.

### Энэтхэгийн соёлын өдрүүд эхэллээ

Монгол дахь Энэтхэгийн соёлын өдрүүд эхлээд байна. Монгол-Энэтхэг улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан "Монгол дахь Энэтхэг Фестиваль 2015-2016"-ийн нээлтийг өнгөрсөн амралтын өдөр Соёлын төв өргөөнд боллоо. Хоёр он дамжин урлаг, соёлын томоохон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөжээ. Энэхүү арга хэмжээнд Энэтхэг улсаас Монгол Улсад сугаад Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сомнат Гош, Монгол-Энэтхэгийн парламентын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл, манай улсад ажиллаж, амьдарч буй энэтхэгчүүд, Энэтхэгт сургууль төгссөн монгол залуус оролцсон.

Энэ үеэр хоёр улсын хамтын ажиллагааны

түүхийг өгүүлэх гэрэл зургийн үзэсгэлэн дэлгэгдсэн юм. Бакула Ринбүүчийн Монгол дахь айлчлал, мөн БНМАУ-ын удирдагч Ю.Цэдэнбалын 1959 онд Энэтхэг улсад хийсэн айлчлалын түүх болон үлдсэн гэрэл зургууд олны анхаарлыг зүйлэсэн татах байлаа.

Элчин сайд Сомнат Гош нээж уг хэлсний дараа Энэтхэг соёл, уламжлалын дагуу зул асаасан юм. Энэтхэг бүхийг Монголын авьяаслаг охид бүхижлэж сонирхуулснаас гадна бясалгалын нэг хэлбэр болох "Йога"-ийн үзүүлбэр толилуулав. Түүнчлэн тус улсын ардын уламжлалт бөмбөрийн хамтлаг "Энэтхэг бөмбөр" хамтлагийн үзүүлбэр үзэгчдээс алга ташилтыг харамгүй хүртлээ.



Утас, факс: 70110187

Захиалгын үнэ: 16,000 төгрөг, улс

'00 2015

р. б № 191 Arddilal Daily  
9th Nov 2015.

# ОЛ, ЭНЭТХЭГИЙН ХАРИЛЦАА

Сомнат Гош: "Мэдээллийн технологийн шилдгийн төлөө" төвийг 20 гаруй сая ам.доллараар байгуулна



Соёлын өдрүүдийн эхлэл болох "Монгол дахь Энэтхэг Фестиваль 2015-1016"-ийн үеэр Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сомнат Гош нэгэн сайхан мэдээ дуулгалаа. Тэрээр "Манай хоёр улсын харилцаа стратегийн түвшинд хүрч, улам өргөжин тэлсээр байна. Энэ нь тунхаглал төдий харилцаа биш юм. Бидний

харилцаа 2500 жилийн тэртээгээс бэхжин, хөгжиж ирсэн түүхтэй. Хэдийгээр хоёр улсын харилцааны үндэс суурь өөрчлөгдсөн ч, харилцаанд өөрчлөлт ороогүй гэж болно. 60-аад жилийн өмнө манай улс социалист системийн бус орнуудаас анхлан Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон. Мөн 1961 онд Монгол Улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орон болох үйл ажиллагааг манай улс хамгийн их дэмжиж оролцсон. Бидний гүнзгий харилцааны хоёр жишээг дурдахад ийм байна. Өнөөдөр Монгол орон хөгжиж буй, ардчилсан, бие даасан тусгаар улс. Монгол Улс цаашид улам илүү хөгжин цэцгэлэнэ гэдэгт итгэж байна. Манай улс тооцоолон бодох технологид дэлхийд тэргүүлж буй.

Тиймээс энэ чиглэлд танай улса, хөрөнгө оруулалт болохуйц томоохон ажлыг эхлүүлээд байгаа. Бид "Мэдээллийн технологийн шилдгийн төлөө" хэмээх тэв байгуулахаар 20 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд Ражив Гандийн нэрэмжит үйлдвэр урлалын сургуулийг зөвхөн техник, технологийн чиглэлээр 5000 гаруй оюутан төгссөн. Уг коллежид л гэхэд гурван сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн. Манай улсын Засгийн газрын зүгээс Монголын боловсролын салбарт хамтарч ажиллах хүсэлтэй байгаа" гэсэн юм.

## Д.Дэмбэрэл: Нэг тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг шинжлэх ухааны салбарт зориулахыг хүссэн

Энэхүү фестивалийн үеэр Монгол-Энэтхэгийн парламентын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл "Манай хоёр улсын харилцаа ёнө эртний түүхтэй. Бидний харилцаа шиг он удаан жилийн түүхтэй харилцаа ховор гэж болно. Манай хоёр орны харилцаа улам нягт болж гүнзгийрч буй нь дээд удирдлагын түвшинд хийгдэж буй олон талт айлчлал, уулзалтуудаас харагдаж байгаа. Энэтхэг улсын Ерөнхий сайд Нарендра Моди айлчлалынхаа

үеэр манай улсад нэг тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээл олгох болсон. Үүнийг шинжлэх ухааны салбарт зарцуулахыг хүссэн. Эндээс манай хоёр улсын эдийн засгийн харилцаа ямар өндөр түвшинд байгааг харж болно. Энэ оны сүүлчээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Энэтхэг улсад айлчилна.

Энэхүү айлчлалууд хоёр орны парламент, Засгийн газар хоорондын харилцааг өргөтгэж буй хэрэг" гэлээ.